Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 2 сарын 23 өдрийн
52 дугаар тушаалын 3 дугаар
Хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн
шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад өгөх
ЗӨВЛӨМЖ
(Маягт №3)

**ХЭНТИЙ АЙМАГ. "ОЮУНЫ ШИМ" ӨЭМТ-д** 2025 оны 04 сарын 02.

| № | Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Зөвлөмж | Хэрэгжүүлэх арга зам |
|---|---|---|---|---|
| **Бүлэг 1.Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд** | | | | |
| **Дэд бүлэг 1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал.** | | | | |
| 1. | Үйлчлүүлэгчид хийгдсэн шинжилгээний яаралтай болон аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх мэдээлэх мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон, мөрддөг байх | 3.1. | Лабораторийн шинжилгээний хариуны аюултай өгөгдлийг тодорхойлох | • Яаралтай шинжилгээний аюултай хариуны өгөгдлийг тодорхойлж, аюултай хариуны бүртгэл хөтлөх.<br>• Яаралтай шинжилгээний аюултай хариуг мэдээлэх үйл ажиллагаанд хяналтын хуудсаар хяналт хийж баримтжуулах. |
| 2. | Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм/-ийн аюулгүй байдлыг хангадаг байх | 4.1. | Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах | • Өндөр эрсдэлт, ижил харагддаг, ижил дуудагддаг эмүүдийн жагсаалтыг дахин хийж батлах, эмүүдийн ялгалт таних тэмдгийг эм бүрд хийх<br>• Ижил нэртэй, өөр тунтай эмийн нэршил, тун, савлагааг хяналтын хуудсаар нарийвчлан хянах<br>• Хяналт үнэлгээний үр дүнг тооцон, авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн дүгнэлт бүхий тайлан бичих |
| 3. | Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийж, унах эрсдлийг тоддорхойлж, гэмтэж бэртэхээс сэргийлдэг байх | 5.2. | Унаж бэртэх эрсдлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандарт болон хавсралтуудыг хэрэгжүүлэх | • Үйлчлүүлэгчийн биеийн байдал, онош болон бусад нөхцөл байдалд үндэслэн унаж гэмтэх эрсдэлийг үнэлдэг шалгуур хуудас хөтлөх<br>• Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчдэд тавих хяналтыг сайжруулах<br>• Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг байгууллагын бүх ажилтнууд таньж мэддэг, сэргийлэх арга хэмжээ авч, тусламж үзүүлдэг байх |

| | | | |
|---|---|---|---|
| **Дэд бүлэг 2. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал** | | | |
| 4. | Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх | 1.1 | ӨЭМ-н төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 26.2.4, 26.2.5 дахь заалт |
| | | | • ӨЭМ Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх журам боловсруулан, батлах<br>• Журмын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах |
| **Дэд бүлэг 3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчид өгөх мэдээлэл** | | | |
| 5. | Лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьдаг байх | 3.3 | Лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн эргэн мэдээллийг сайжруулах |
| | | | • Лавлагаа шатлалд илгээж тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээ, үйлчилгээний талаарх эргэн мэдээллийг авч, бүртгэлтэй ажиллах, үр дүнг дүгнэж байх<br>• Үргэлжлүүлэн хянаж, тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэхэд анхаарах |
| **Дэд бүлэг 4. Үзлэг, оношлогоо, эмчилгээ** | | | |
| **А. Амбулаторийн тусламж, үйлчилгээ** | | | |
| 6. | Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалттай байх. | 1.3 | Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлийн стандарт MNS 4621:2008 –ын дагуу амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг гарган батлах |
| | | | • Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг шинэчлэн /үйлдэл, ажилбар бүрт тохирох стандартын хамт жагсаах/<br>• Эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, баталгаажуулан, гарын авлагаар хангах.<br>• Ажилбар үйлдлийг стандартын дагуу хийдэг, хянадаг, үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.<br>• Эмч мэргэжилтнүүд үйлдлийг хийх ур чадвар эзэмшсэн байдалд хяналт хийх. |
| **Дэд бүлэг 5. Халдварын сэргийлэлт хяналт** | | | |
| 7. | ЭМА-танд ХСХ-ийн мэдлэг олгох сургалт хийдэг байх | 1.4 | ЭМС-ийн 2017 оны А\505 тушаал, 2019 оны А\537, А\538, А\539 дүгээр тушаалаар батлагдсан журам, зааврууд холбогдох бусад тушаал, шийдвэрүүдийг мөрдөж ажиллах |
| | | | • ХСХ багийн гишүүдийг чадавхжуулах, сургагчаар бэлтгэж ажиллуулах<br>• Сургагчаар бие даан сурах, цахимаар сурах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллах<br>• ХСХ-ын багийн гишүүдээр ЭМС-ийн тушаалаар батлагдсан ХСХ-тай холбоотой бүх журам, зааврuудаар сургалт хийх хичээлийг (Power Point) бэлтгүүлэх<br>• ЭМС-ийн тушаалаар батлагдсан ХСХ-тай холбоотой бүх журам, зааврuудаар бүх ажилчдад ажлын байранд сургалт хийж үр дүнг тооцож ажиллах<br>• Сургалтын явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулах |
| 8. | Үйлчлүүлэгчид тарилга, арьс, салст цоолох ажилбар хийхдээ аюулгүй | 2.1 | ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын 13 дугаар |
| | | | • Үйлчлүүлэгчид тарилга болон арьс салст цоолох ямар нэгэн ажилбар хийхдээ ажилбар гүйцэтгэх тухайн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байдлыг хангаж ажиллах | | хавсралтаар батлагдсан “Тарилгын аюулгүй байдлын заавар”-ыг уншиж судлах, мөрдөж ажиллах | орчинд тавигдах халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах<br>• Ажилбарын үед халдвараас сэргийлэх зарчмуудыг мөрдөж ажиллах<br>• Арьс салст цоолох ажилбарын явцад тусгайлан бэлтгэсэн хяналтын хуудсаар үнэлгээ хийж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах |
| 9. | Эмнэлгийн ажилтны дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл судалгаатай, дархлаажуулалтад хамруулдаг байх | 3.3 | ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар”-ыг мөрдөж ажиллах | • ЭМА-нд хийсэн дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг үүсгэж ажиллах<br>• Архаг халдваргүй, эсрэг заалтгүй бол эмнэлгийн ажилтанг В вируст гепатитийн 3 тун вакцинаар дархлаажуулж мэдээллийн санд бүртгэх<br>• В вируст гепатитийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтныг дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулж мэдээллийн санд бүртгэх<br>• Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан, өвдсөн бол дархлаа тогтоцын шинжилгээнд хамрагдсан ажилчдыг мэдээллийн санд бүртгэх<br>• Тусламж, үйлчилгээнд оролцон ажиллаж байгаа ажилтанг улирлын томуугийн вакцинд хамруулж ажиллуулах<br>• Шинээр ажилд орж буй эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэнүүдийн дархлаажуулалтын мэдээллийг мэдээллийн санд бүртгэх<br>• Дархлаажуулалтын мэдээллийн сангийн байнгын ажиллагаанд тавих ХСХ-ын багийн хяналтыг сайжруулах |
| 10. | Багаж хэрэгслийн арчилгаа савалгаа хадгалалт зөв байх | 4.5 | ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүү-лэх, ариутгах” зааварыг уншиж судлан мөрдөж ажиллах | • Тарианы өрөө бусад ажилбарын өрөөнд байгаа ариун материалын пакетны гаднах тэмдэглэгээ, битүүмжлэл, хэрэглээ, хадгалалтад хяналтын хуудсаар хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах<br>• Мөн ариун материал хадгалж буй бикс, шкаф зэрэг хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах<br>• Ариун материал хадгалах зориулалтын шүүгээг нэмэгдүүлэх<br>• Ариутгал, халдваргүйжүүлэлтийн явц, хэрэгжилтэд ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11. | Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх | 5.3 | ЭМС-ийн 2019 оны А\538 дугаар тушаалын нэгдүгээр, хоёрдугаар хавсралтаар батлагдсан заалтуудыг уншиж судлах, мөрдөж ажиллах | • ӨЭМТ-ийн эмч нарын бичиж буй антибиотекийн сонголт, хэрэглээ, анитбиотекийн бичилтээ багасгаж буй байдалд мөн иргэдийн антибиотекийн хэрэглээнд судалгаа хийж ажиллах<br>• Иргэдийн жоргүйгээр антибиотек авч хэрэглэж байгаад судалгаа хийх дүн шинжилгээ хийж ажиллах, судалгааны дүнд үндэслэн цаашид хийх ажлын төлөвлөгөөнд үйл ажиллагаа тусгаж ажиллах<br>• Архаг хууч өвчтэй олон хоног нянгийн эсрэг эм хэрэглэсэн үйлчлүүлэгчид нянгийн эсрэг тэсвэржсэн байдлыг дараагийн шатлалд илгээж антибиотекийн мэдрэг чанарыг тодорхойлуулах<br>• Иргэдэд анитбиотекийн хэрэглээтэй холбоотой мэдээлэл сургалт, сурталчилгааг сайжруулах, нэмэгдүүлж ажиллах |
| **Бүлэг 2. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт.** | | | | |
| **Дэд бүлэг 1. Засаглал, удирдлага, манлайлал** | | | | |
| 12. | Судалгаа шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжилтэнд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх | 3.1 | Стратеги төөлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | • Эмнэлгийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт үнэлгээ хийх<br>• Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эмнэлгийн удирдлагын багийн хурлаар хэлэлцэн, тэмдэглэл хөтлөх<br>• Стратеги төөлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлт, үр дүнг тооцсон дэлгэрэнгүй тайлан бичих |
| 13. | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийгдэх хяналт, үнэлгээ хэвшсэн байх | 5.1. | Монгол улсын засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах | • Дотоод хяналт шалгалт хийх графикын дагуу хяналтын хуудсаар хяналтыг тогтмол, ойр давтамжтай хийж, дүгнэн, хяналтын үр дүнг тооцох, тайлан бичих<br>• Дотоод хяналт, үнэлгээний дүгнэлтийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, тэмдэглэл хөтлөж, асуудлыг шийдвэрлэх |
| **Дэд бүлэг 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага** | | | | |
| 14. | Төв нь тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх | 2.1. | Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А565 тушаалд заасан ЧАБ-ын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх | • Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалд заасан ЧАБ-ын албаны хэрэгжүүлэх чиг үүрэгт заасны дагуу тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг тогтмол хийх<br>• Тусламж үйлчилгээний хяналт үнэлгээ хийх чиглэл бүрээр хяналтын хуудас боловсруулж, хяналт үнэлгээ хийх<br>• Хяналт үнэлгээний үр дүнг тооцож, сайжруулах арга хэмжээ авах |
| 15. | Үйл ажиллагаа үзүүлж буй тусламж | 2.2. | Тусламж, үйлчилгээний | • Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын өвөрмөц |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих, өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт дүн шиинжилгээ хийдэг байх | | чанарын үзүүлэлтийг тооцох аргачлал, үзүүлэлтийн бодит байдлыг хангах | үзүүлэлтийг нэгж, хэсгийн чиглэл бүрээр боловсруулах<br>• Жил бүр чанар аюулгүй байдлын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж сайжруулах ажлыг зохион байгуулах<br>• Өөрийн үзүүлж буй тусламж, үйлчилгээ, чанарын үзүүлэлтийг ижил түвшний ЭМБ-ын үзүүлэлттэй харьцуулсан судалгаа, дүгнэлттэй ажиллах |
| 16. | Чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээ зохион байгуулдаг байх | 2.3. | ЭТҮ-ний чанар сайжруулах арга хэрэгслийг бүрэн хэрэгжүүлэх | • ЭТҮ-ний чанарын сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах<br>• ЭТҮ-ний чанар сайжруулах арга /мэдээлэл цуглуулах, аудит хяналт, фокус ярилцлага, шууд үзлэг, ажиглалт, чанарын бүлгэм, чанарын өдөрлөг, СОФЕ арга, Кайзан саналын систем, ажиглалтын тойм үзлэг/, хэрэгсэл /асуумж, судалгаа, хяналтын хуудас, өрнөл зураг, асуудлын мод, шалтгаан нөлөөллийн зураглал, паретагийн диаграмм/-ийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцох |
| 17. | Тусламж үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр, нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх | 4.2. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг судлан, хэрэгжүүлэх | • Эмнэлгийн үйл ажиллагааны онцлогт тохируулан тохиолдол бүртгэх хариу арга хэмжээ авах журам боловсруулж, батлах<br>• Тохиолдлыг бүртгэж, дүн шинжилгээ хийх<br>• Бүртгэсэн тохиолдлыг хэлэлцүүлэн, арга хэмжээ тооцдог байх<br>• Тохиолдлын сан үүсгэх |
| 18. | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой сургалтыг эмнэлгийн нийт ажилтнуудад /эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнуудад/ тогтмол зохион байгуулдаг байх | 4.4. | Аюулгүй байдлын сургалт зохион байгуулах | • Сургалтын удирдамж, хөтөлбөр боловсруулж батлах<br>• Сургалт зохион байгуулах<br>• Сургалтын үр дүнг тооцох / сургалтын өмнөх болон дараах сорил авч дүгнэх/<br>• Сургалтанд оролцогчдыг бүртгэж, гарын үсэг зуруулах<br>• Сургалтын тайлан бичих |
| **Дэд бүлэг 3. Хүний нөөцийн хөгжил** | | | | |
| 19. | Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авдаг байх | 1.4. | Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн үнэлгээ хийлгэх | • Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх<br>• Үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч, дүгнэлттэй ажиллах<br>• Ажилчдын хөдөлмөрийн норм нормативын судалгаа хийж, ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авч, баримтжуулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20. | Үзүүлж байгаа тусламж үйлчилгээндээ дүн шинжилгээ хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг, хэвшсэн байх | 3.3. | Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг байх | • Эмнэлгийн мэргэжилтнүүд эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх<br>• Аймгийн ЭМГ болон бусад байгууллагаас зохион байгуулсан хуралд илтгэл хэлэлцүүлэх<br>• Тухайн онд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын тайланг бичих |
| **Дэд бүлэг 4. Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал** | | | | |
| 21. | Байгууллага нь ТҮ-ний үзүүлэлтүүд Хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, санхүүгийн 5 жилээс доошгүй хугацаагаар үүсгэсэн мэдээллийн сантай байх | 1.3 | Өрхийн ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартыг мөрдөж ажиллах | • ӨЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээний санг үүсгэн жил бүр баяжилт хийж ажиллах<br>• Тоног төхөөрөмжийн мэдээний сангийн баяжилтийг сайжруулж, тогтмол ажиллуулах<br>• Мэдээллийн сангуудын үйл ажиллагаанд жилээр харьцуулалт, дүн шинжилгээ хийж ажиллах<br>• Мэдээллийн сангуудын мэдээллийг төлөвлөлт, судалгаа, шийдвэр гаргалтад ашиглаж ажиллах |
| 22. | Зайнаас (телемедцина) эмнэлзүйн зөвлөгөө авдаг тогтолцоог бүрдүүлсэн байх | 3.4 | Өрхийн ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартыг мөрдөж ажиллах | • Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө авах журмыг боловсруулж, батлах<br>• Лавлагаа шатлалын ЭМБ-аас зайнаас оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан тохиолдол бүрийг бүртгэж ажиллах<br>• Зайнаас эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, ажилчдын бүртгэл судалгаатай ажиллах<br>• Журмын хэрэгжилтэд ЭМТҮЧАБ-ын баг хяналт тавьж ажиллах |
| **Дэд бүлэг 5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ** | | | | |
| 23. | Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах аюулгүй ажиллагааны сургалт хийдэг байх | 3.2 | ЭМС-ийн 2018 оны А\344 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт мөн тавдугаар хавсралтаар батлагдсан гарын авлагыг мөрдлөг болгон ажиллах | • ӨЭМТ-д ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэжлийн инженерээр сургалт хийлгэж, сургалтын үр дүнг тооцож ажиллах<br>• Сургалтад эмнэлгийн тоног төхөөрөмж дээр ажилладаг эмч, сувилагч нарыг суулгаж анхан шатны мэдлэгтэй болгох<br>• Тоног төхөөрөмж ажиллуулах бүрд сувилагчаар аюулгүй ажиллагааны зааврыг уншуулж гарын үсэг зуруулах<br>• Тоног төхөөрөмжийн сургалтын явц, үр дүнд ЭМТҮЧАБ-ын баг хяналт тавьж ажиллах |
| 24. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх | 3.5 | ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартын холбогдох | • Эмнэлгийн нэг тоног төхөөрөмжид ноогдох талбайн хэмжээг стандартад заасан хэмжээнд нийцүүлж ӨЭМТ-ийн Сэргээн засах өрөө, лаборатори, яаралтай тусламжийн өрөөг зохион |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | заалтуудыг судлан мөрдөж ажиллах | байгуулж эмнэлгийн тоног төхөөрөмжийг байрлуулах<br>• Эмнэлгийн тоног төхөөрөмжийн байршил, хэвийн ажиллагаанд ЭМТҮЧАБ-ын баг, дотоод хяналтын багаас тавих хяналтыг сайжруулах |
| **Дэд бүлэг 6. Барилга инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа.** | | | | |
| 25. | Байгууллага нь барилга инженерийн байгууламжийн байршил бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем зураглалтай байх | 1.1 | Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS6392:2013 стандартын /4.1, 4.2./ заалтыг судлан мөрдөж ажиллах | • ӨЭМТ-ийн 2-р байранд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгааг нэн даруй зогсоож, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах |
| 26. | Галын хорыг шаардлагатай өрөө, нэгжид зохих журмын дагуу байрлуулж, хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэлийг хөтөлдөг байх | 4.5 | Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн 2-р бүлгийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах | • Галын хорны тоог ӨЭМТ-ийн 2 байрны м2-д нийцүүлж нэмэгдүүлэх<br>• Галын хорыг шаардлагатай бүх цэгт байршуулж сар бүр цэнэглэлтийг шалгаж, хөдөлгөж байх<br>• Галын хорны техник ашиглалтын паспортад тэмдэглэл хийх |
| **Бүлэг 3: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд** | | | | |
| **I.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтүүд** | | | | |
| 27. | Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгаа хийж үр дүнг тооцсон | 1.4 | “Өрхийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292:2017 стандартын 1 9.3, 19.4. 19,5 заалт мөрдөн хэрэгжүүлэх | • Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгаа хийж дүгнэлт гарган тайлагнах<br>• Судалгааны дүгнэлтэд үндэслэн төрийн болон ТББ-тай хамтран арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх<br>• Судалгааны тайлантай, үр дүнг тооцох. |
| 28. | Халдварт бус өвчин үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийдэг байх | 2.5 | Өрхийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292:2017 стандартын 1 9.3, 19.4. 19,5 заалт мөрдөн хэрэгжүүлэн тандалт судалгаа хийж үр дүнг тооцон ажиллах | • Халдварт бус өвчин үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийх<br>• Судалгааны тайлан дүгнэлттэй үр дүнг тооцох<br>• Авсан арга хэмжээний тайланг жил бүр бичих<br>• Халдварт бус өвчин бууруулах ажил зохион байгуулж ажиллах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29. | Элэг, улаан хоолой, ходоод бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж хянадаг байх | 6.5 | Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн 12.3.3 заалтын мөрдөх , ЭМС-ын А/360 тушаалын 3.2.1, 3.2.2 заалтыг хэрэгжүүлэх | • Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран бүдүүн шулуун гэдэсний хавдар – өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээг хийдэг болох<br>• Ходоод улаан хоолойн хавдар илрүүлэх – дурангийн шинжилгээ хийлгэж, хавдрын мэрэгжлийн эмчтэй харилцан уялдаа холбоотой ажиллаж хавдрыг эрт илрүүлэн эмчлэн эрүүлжүүлэх |
| **II.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд.** | | | | |
| **1.Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 30. | Эх нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр батлагдсан бодлого, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлдэг байх | 1.1 | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагаа MNS 5292:2017 стандартын 15.3.1, 15.3.3 дэхь заалт,<br>ЭМС-ын 2021 оны А/760 дугаар тушаал, ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын заалтыг хэрэгжүүлэх | • ӨЭМТ-д холбогдох заалтыг тусган төлөвлөгөө боловсруулан ӨЭМТ-ийн даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллах<br>• Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэдэг, тайлантай байх<br>• Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг гаргаж баталгаажуулах<br>• Шинээр эх, нярайн тусламж, үйлчилгээтэй холбоотой гарч буй тушаал зааврuudтай танилцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт тогтмол явуулж, хэрэгжилтийг ханган ажиллах |
| 31. | Эмч сувилагч нарыг нярайн эрт үеийн болон эх барихын нэн шаардлагатай тусламжийн сургалтанд хамруулсан байх | 1.5 | ӨЭМ-н төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 7.2 дахь заалт, ЭМС-ын 2021 оны А/760 дугаар тушаалыг хэрэгжүүлэх | • Эмнэлгийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх сургалтын бодлого төлөвлөгөө гарган батлах, үр дүнг тооцох<br>• Сургалт бүрт удирдамж, хөтөлбөр гаргах, бүртгэл тайлангаар баримтжуулах, сургалтын өмнөх, дараах сорил авч үр дүнг тооцох |
| **2.Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ** | | | | |
| 32. | Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх | 1.1 | ЭМС-ын 2019 оны “Заавар батлах тухай” А/593 тушаалын “ХӨЦМ-ийн хүснэгтэн товхимол” хавсралтыг хэрэгжүүлэх | • ХӨЦМ-ийн сургалтанд эмч мэргэжилтнийг бүрэн хамруулах<br>• ЭМС-н А/593 дугаар тушаалаар баталсан маягт ашиглах<br>• 0-5 хүртлэх насны хүүхдийн өсөлтийн зөв хэмжиж үнэлэн ӨЭ-3а,б маягтыг зөв хөтлөх<br>• Хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцох |
| 33. | Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж заавриг дагуу хийдэг байх | 2.4 | ЭМС-н 2017 оны “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга | • Өсвөр үеийн хүүхдийн өвчлөл, эрсдлийн судалгаатай болох<br>• Удирдамжийг мөрдөж ажиллах<br>• Хэрэгжилтэнд хяналт хийж, үр дүнг тооцох |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хэмжээний тухай" А/399 дугаар тушаалыг хэрэгжүүлэх | |
| **4. Халдварт бус өвчний тусламж үйлчилгээ** | | | | |
| 34. | Тусламж үйлчилгээний жагсаалтанд заасан халдварт бус өвчний үзлэг, оношлогоо, эмчилгээ, хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг байх | 1.2 | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 6.10, 8.5, 11.1 дэх заалтыг хэрэгжүүлэх | • Оношилгоо, эмчилгээ, үйлдлийн стандарт, удирдамж, зааврын жагсаалт шинэчлэн гарган батлах, мөрдөлтөд хяналт үнэлгээ хийх, хариу арга хэмжээний үр дүнг тооцох<br>• Ажилтан бүрийг оношилгоо эмчилгээний чиглэлээр ашиглаж буй стандарт заавруудаар хангах<br>• Шаардлагатай стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврыг ашиглах боломжоор хангагдсан байх /Цахим, UP TO DATE олон улсын платформ, хавтас, номын сан, гарын авлага/ ашиглалтын хувийг нэмэгдүүлэх |
| **7. Халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 35. | Хүн амд халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээг үзүүлэх | 1.1 | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 23.1 , 23.3 заалт, мөрдөж ажиллах | • Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн үйлчлүүлэгчийн оношлогоо эмчилгээтэй холбоотой эргэн мэдээллийг авч хяналтыг хийх<br>• Тусламж үйлчилгээний төрөл бүрээр үзлэг оношлогоо эмчилгээ хяналтыг хийсэн мэдээ тайланг зөрүүгүй гаргах |
| **8.Уламжлалт анагаах ухаан болон сэргээн засах тусламж үйлчилгээ** | | | | |
| 36. | Уламжлалт анагаах ухааны жагсаалтанд заасан төрлөөр тусламж үйлчилгээ үзүүлдэг байх. | 1.1 | "ӨЭМ-н төвийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5292:2017 стандартын 7.11; 9.1.10 дэх заалт, ЭМС-ын 2019 оны А/378 дугаар тушаалын хавсралтын 4.2; 6 дахь заалт, ЭМС-ын 2022 оны А/55 дугаар тушаалыг хэрэгжүүлэх | • Холбогдох тушаалыг үндэслэн өөрийн эмнэлэгт үзүүлэх сэргээн засах, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний жагсаалтыг батлах<br>• Жагсаалтын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөг тус тусад нь гаргаж, тоног төхөөрөмжөөр хангаж, хүний нөөцийг /эмч, сувилагч/ мэргэшүүлэх, УАУ-ны их эмчтэй болох<br>• Чанарын үзүүлэлтийг батлан гаргаж хэмждэг, дүн шинжилгээ хийж ажиллах |
| **9. Сувилахуйн тусламж үйлчилгээ** | | | | |
| 37. | Эмнэл зүйн ур чадварын өрөөг зохион байгуулж, шаардлагатай хэрэгслээр хангасан, сургалт хийдэг байх | 2.4 | "ӨЭМ-н төвийн бүтэц үйл ажиллагаа" MNS 5292:2017 стандартын 16.1 дэх заалт, MNS 4621-2008 стандартад заасан сувилахуйн тусламж | • Ажлын байранд зохион байгуулах сувилагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон хөтөлбөрийг жилээр төлөвлөн, хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж хэвших,<br>• Ур чадварын сургалт зохион байгуулах нөхцөл боломжоор хангах,<br>• Өрхийн сувилахуйн тусламжийг үзүүлэх болон сургалтын иж бүрдэл бэлэн байдлыг сайжруулах. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээг хэрэгжүүлэх | |
| 38. | Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийг хийх эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг үнэлж, сургадаг байх. | 2.6 | Сувилахуйн тусламж үйлчилгээнд үзүүлж буй гардан үйлдлийн жагсаалт гарган батлуулж хэрэгжилтэнд хяналт тавих. | • Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн жагсаалтыг гарган батлах<br>• Батлагдсан жагсаалтын дагуу гардан үйлдлэл хийж байгаа байдалд хяналт үнэлгээ хийх хяналтын хуудас боловсруулан хяналт хийж, үр дүнг тооцох<br>• Хяналт үнэлгээний үр дүнг дүгнэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах /сургалт, хэлэлцүүлэг, аян өдөрлөг гэх мэт/. |
| **10. Яаралтай тусламж үйлчилгээ** | | | | |
| 39. | Яаралтай тусламжийн үеийн эрэмбэлэн ангилалтыг хийх, удирдамж, эмнэлзүйн зааврыг мөрддөг байх | 1.2 | ӨЭМ-н Төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292:2017 стандартын 12.2, 12.3, 12.4 заалт, ЭМС-ын 2021 оны А/814 дугаар тушаалын 5.1 заалт, 2-р хавсралтыг хэрэгжүүлэх | • Эмнэлгийн мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн үеийн эрэмбэлэн ангилалтыг хийх, удирдамж, эмнэлзүйн зааврын талаар давтан сургалтанд хамруулах<br>• Багаар тусламж үзүүлэх дадлагыг тогтмол хийж, бэлэн байдлыг хангах<br>• Эмнэлгийн мэргэжилтнүүдийн амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ур чадварт тогтмол хяналт, үнэлгээ хийх |
| **11. Эмийн менежмент ба зохистой хэрэглээ** | | | | |
| 40. | Эмзүйн тусламж үйлчилгээнд мөрддөг журамтай, хэрэгжилтэнд хяналт тавьдаг байх. | 1.2 | “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292:2017 стандартын 9.2.7, 24.4 дах заалт, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага 5260-2015 стандарт 10.1,10.2, 10.3,10.4,10.6, 10.8, 10.9 заалтыг хэрэгжүүлэх. | • Эм зүйн тусламж үйлчилгээг зохицуулах журам боловсруулж /эмийн аюулгүй байдлын 5-н зөвийн зарчмыг тусгах/ батлах,<br>• Нөөцийн эмийн хадгалалтын шаардлагыг хангуулан ажиллах,<br>• Эмийн хадгалалт, ангилал, ялган таних аргыг нэвтрүүлэн дотоодын хяналтыг сайжруулах,<br>• Эмийн зохистой хэрэглээ ижил дуудагддаг, ижил харагддаг, өндөр эрсдэлт эмийн ялган таних тэмдэглэгээг эм хадгалж байгаа хэсэгт бүрт ижил хийдэг байх<br>• Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн бүртгэл, зарцуулалт, хадгалалтанд хяналт тавьдаг байх. |
| 41. | Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, инсулин, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм гэх мэт/-ийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлсэн байх | 3.7 | Эрүүл мэндийн сайдын 2015 оны “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг имлортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” А/68 тоот | • Өндөр эрсдэлт, ижил харагдаж, дуудагддаг эмийн зохистой хэрэглээний журам, жагсаалтыг шинээр боловсруулан, баталж, эмч мэргэжилтнүүдэд сургалт хийх<br>• Журмын хэрэгжилтэнд дотоодын хяналтыг үр дүнтэй хийх, сайжруулах ажлыг зохион байгуулах<br>• Өндөр эрсдэлтэй, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хаягжилт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | тушаалын 4.3.4, 4.5, 5.6.3 дах заалт, Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг ханган ажиллах | хадгалалтын талаар эмнэлгийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл байрлуулсан бүх хэсэгт зохион байгуулалтыг сайжруулах, хяналт тавьж ажиллах |

Шинжээчдийн баг:

Ахлагч: Ц. Дариймаа

Гишүүд: М.Оюунчимэг

Ж.Эрдэнэцэцэг

Ч.Батнасан

Хянасан: С.Мөнхсүх /ТҮЧМИА-ны мэргэжилтэн/